

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Улаанхус сумын Хөххөтөл хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БӨА-2022/100/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Өлгий хот

2022 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга  
бөгөөд тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 70422954 Цахим хаяг: huanganm@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

“Уужим алтай Аудит” ХХК-ны аудитор: Б.Галымбек

Утас: 99101563 Цахим хаяг: uujimaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

## **Агуулга**

---

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3. Аудитын тайлан.....	15
3.1 Ерөнхий зүйл.....	15
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	16
3.4 Материаллаг байдал .....	16
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	17
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	18
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	19
3.8 Аудитын гол асуудал .....	20
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	20
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	20
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	21
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	21
4. Аудитын илрүүлэлт .....	21
4.1 Залруулсан алдаа .....	21
4.2 Төлбөрийн акт .....	21
Байхгүй .....	21
4.3 Албан шаардлага .....	21
4.4 Зөвлөмж.....	21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	23

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgi@audit.gov.mn

УЛААНХУС СУМЫН ХӨХХӨТӨЛ  
ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
З.АЛИЯ ТАНАА

᠒᠐᠒᠒-᠐᠒-᠒᠑ № 184  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанхус сумын Хөххөтөл хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Улаанхус сумын Хөххөтөл хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. Цэцэрлэг нь өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар хүнсний материалын дансны 15.9 сай төгрөгийн үлдэгдэл бодитой байгаа гэж тооллогын бүртгэл ирүүлсэн мөртөлөө хүнсний материалын данснаас урьд жилүүдэд хоолны зардлын төсвөөс авсан гэх нийт 16.7 сая төгрөгийн материалыг хүнсний материалд бүртгэж ирснийг Цэцэрлэгийн эрхлэгчийн 2021 оны 09 тоот тушаалаар 6.5 сая төгрөгийг үндсэн хөрөнгө дансанд, 4.8 сая төгрөгийг аж ахуйн материалын дансанд шилжүүлэн, 5.4 сая төгрөгийн материалыг зарцуулснаар данснаас хасахдаа бүрдүүлсэн баримтууд нь тухайн үед бүрдүүлсэн баримт эсэх нь эргэлзээтэй, үнэн зөвийг хянаж баталгаажуулаагүй.

2. Цэцэрлэгийн эрхлэгчийн 2021 оны 12 дугаар сарын 12-ний өдрийн 15 тоот тушаалаар жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийх комиссыг томилж тооллого хийгдсэн боловч зарим хөрөнгийн тооллогын бүртгэлийн дүн нь санхүүгийн тайлангийн үлдэгдлээс зөрүүтэй, зарим хөрөнгийн үлдэгдлийг бүрэн тоолоогүй, нягтлан бодогч нь тооллогын дүнг үндэслэн тооцоо бодож үлдэгдлийг баталгаажуулаагүйгээс нийтдээ 86.5 сая төгрөгийн зөрчилтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, 26 дугаар зүйлийн 26.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.1.4, 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн

тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2 дахь заалт болон иж бүрэн байх, оршин байх, толилуулга гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>42944457.04</u></b>	<b><u>40580533.84</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	2349791.20	398171.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1474040.00	398171.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	875751.20	0.00
3351	Байгууллагаас авах авлага	875751.20	0.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	40594665.84	40182362.84
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	40594665.84	40182362.84
35410	Бичиг хэргийн материал	1550600.00	1500000.00
35420	Аж ахуйн материал	7976550.00	13977970.00
35440	Түлш, шатах тослох материал	4527265.84	410002.84
35460	Хүнсний материал	15935690.00	13700330.00
35470	Бусад хангамжийн материал	10604560.00	10594060.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>720869560.40</u></b>	<b><u>708674241.91</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	720869560.40	708674241.91
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	715865560.40	703670241.91
39201	Барилга, байгууламж, орон сууц	552703834.50	706703834.50
39202	Хуримтлагдсан элэгдэл	-31806426.80	-41012859.80
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	21011636.00	29117636.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-8391786.30	-12462593.23
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	34831332.00	34831332.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-20228442.82	-25574842.66
39214	Бусад үндсэн хөрөнгө	16776787.00	16776787.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-11659173.18	-13336851.90
39216	Дуусаагүй барилга, байгууламж	154000000.00	0.00
39217	Ном	8627800.00	8627800.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	5004000.00	5004000.00
39301	Програм хангамж	825000.00	825000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-825000.00	-825000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	5004000.00	5004000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>763814017.44</u></b>	<b><u>749254775.75</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>4116953.00</u></b>	<b><u>755650.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	4116953.00	755650.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	4116953.00	755650.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	70663.00	0.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	4046290.00	755650.00
41361	Байгууллагад төлөх өглөг	3023570.00	618000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1022720.00	137650.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>759697064.44</u></b>	<b><u>748499145.75</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	759697064.44	748499145.75

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	13856951.00	13856951.00
51101	Өмч: - төрийн	13856951.00	13856951.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	744745401.44	733547482.75
51210	Өмнөх үеийн үр дүн	744745401.44	744745401.44
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	-11197918.69
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1094712.00	1094712.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>763814017.44</b>	<b>749254795.75</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>320,547,617.00</b>	<b>292,371,100.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,725,080.00</b>	-
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	2,725,080.00	-
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	2,725,080.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,725,080.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>317,822,537.00</b>	<b>292,371,100.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	303,636,900.00	280,596,600.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	9,499,000.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	294,137,900.00	280,596,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	205,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	205,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	11,954,933.00	11,569,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	11,954,933.00	11,569,500.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	2,230,704.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	2,230,704.00	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	-	-
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	-	-
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>319,116,116.90</b>	<b>303,569,018.49</b>

<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>319,116,116.90</b>	<b>303,569,018.49</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	316,213,712.90	303,569,018.49
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	232,725,023.00	224,076,086.00
210101	Үндсэн цалин	200,605,523.00	195,040,686.00
210104	Урамшуулал	19,826,400.00	16,742,300.00
210105	Гэрээт ажлын хөлс	12,293,100.00	12,293,100.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	33,200,300.00	30,114,600.00
210201	Тэтгэврийн даатгал	23,363,100.00	21,191,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,459,300.00	2,230,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,967,400.00	1,784,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	491,900.00	446,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,918,600.00	4,461,400.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	12,957,037.16	11,831,963.00
210301	Гэрэл, цахилгаан	2,289,970.00	611,300.00
210302	Түлш, халаалт	9,693,167.16	11,220,663.00
210303	Цэвэр, бохир ус	973,900.00	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,984,790.00	3,884,310.00
210401	Бичиг хэрэг	1,465,500.00	1,447,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,111,290.00	991,515.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	375,000.00	344,968.00
210404	Ном, хэвлэл	62,800.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	970,200.00	1,100,827.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	12,136,475.00	12,845,641.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	37,280.00	1,018,364.00
210502	Хоол, хүнс	12,076,195.00	11,827,277.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	23,000.00	-
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	104,600.00	223,200.00
210702	Дотоод албан томилолт	104,600.00	223,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	300,000.00	291,900.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	41,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	250,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	20,805,487.74	20,301,318.49
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,202,500.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	19,602,987.74	20,301,318.49
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	2,902,404.00	-
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	2,230,704.00	-
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	2,230,704.00	-
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	671,700.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	671,700.00	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>1,431,500.10</b>	<b>(11,197,918.49)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>1,431,500.10</b>	<b>(11,197,918.49)</b>

Төгрөгөөр

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	13,856,951.00	1,094,712.00	743,313,901.34	758,265,564.34
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>13,856,951.00</b>	<b>1,094,712.00</b>	<b>743,313,901.34</b>	758,265,564.34
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн			1,431,500.10	1,431,500.10
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>13,856,951.00</b>	<b>1,094,712.00</b>	<b>744,745,401.44</b>	759,697,064.44
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>13,856,951.00</b>	<b>1,094,712.00</b>	<b>744,745,401.44</b>	759,697,064.44
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>13,856,951.00</b>	<b>1,094,712.00</b>	<b>744,745,401.44</b>	759,697,064.44

D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн			-11,197,918.69	-11,197,918.69
D09	<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>13,856,951.00</b>	<b>1,094,712.00</b>	<b>733,547,482.75</b>	<b>748,499,145.75</b>

Төгрөгөөр

#### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>308323537.00</u></b>	<b><u>292166100.00</u></b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b><u>308323537.00</u></b>	<b><u>292166100.00</u></b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	294137900.00	280596600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	294137900.00	280596600.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	11954933.00	11569500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	11954933.00	11569500.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	2230704.00	0.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	2230704.00	0.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>307923537.00</u></b>	<b><u>290566100.00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b><u>307923537.00</u></b>	<b><u>290566100.00</u></b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b><u>305021133.00</u></b>	<b><u>290566100.00</u></b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	234128400.00	223070900.00
210101	Үндсэн цалин	202008900.00	194035500.00
210104	Урамшуулал	19826400.00	16742300.00
210105	Гэрээт ажлын хөлс	12293100.00	12293100.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	33200300.00	30114600.00
210201	Тэтгэврийн даатгал	23363100.00	21191800.00
210202	Тэтгэмжийн даатгал	2459300.00	2230700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1967400.00	1784600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	491900.00	446100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4918600.00	4461400.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	11954933.00	11359500.00
210301	Гэрэл, цахилгаан	1624170.00	1893000.00

210302	Түлш, халаалт	10228563.00	7466500.00
210303	Цэвэр, бохир ус	102200.00	2000000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>2764500.00</b>	<b>2790600.00</b>
210401	Бичиг хэрэг	523100.00	923200.00
210402	Тээвэр, шатахуун	888000.00	555000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	375000.00	467000.00
210404	Ном, хэвлэл	62800.00	50200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	915600.00	795200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>21260400.00</b>	<b>22026600.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	174400.00	544600.00
210502	Хоол, хүнс	20527000.00	21119300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	559000.00	362700.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>0.00</b>	<b>210000.00</b>
210604	Урсгал засвар	0.00	210000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>104600.00</b>	<b>223200.00</b>
210702	Дотоод албан томилолт	104600.00	223200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>300000.00</b>	<b>333700.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	83700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300000.00	250000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1308000.00</b>	<b>437000.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1308000.00	437000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2902404.00</b>	<b>0.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2230704.00</b>	<b>0.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	2230704.00	0.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>671700.00</b>	<b>0.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	671700.00	0.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>400000.00</u></b>	<b><u>1600000.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>400000.00</b>	<b>1600000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>400000.00</b>	<b>1600000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>400000.00</b>	<b>1600000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	400000.00	1600000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-400000.00</u></b>	<b><u>-1600000.00</u></b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>0.00</u></b>	<b><u>0.00</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн</b>		

	үлдэгдэл
--	----------

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	292166100.00	292166100.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	292166100.00	292166100.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	292166100.00	292166100.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	223070900.00	223070900.00
210101	Үндсэн цалин	194035500.00	194035500.00
210104	Урамшуулал	16742300.00	16742300.00
210105	Гэрээт ажлын хөлс	12293100.00	12293100.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	30114600.00	30114600.00
210201	Тэтгэврийн даатгал	21191800.00	21191800.00
210202	Тэтгэмжийн даатгал	2230700.00	2230700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1784600.00	1784600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	446100.00	446100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4461400.00	4461400.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	11359500.00	11359500.00
210301	Гэрэл, цахилгаан	1893000.00	1893000.00
210302	Түлш, халаалт	7466500.00	7466500.00
210303	Цэвэр, бохир ус	2000000.00	2000000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2790600.00	2790600.00
210401	Бичиг хэрэг	923200.00	923200.00
210402	Тээвэр, шатахуун	555000.00	555000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	467000.00	467000.00
210404	Ном, хэвлэл	50200.00	50200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	795200.00	795200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	22026600.00	22026600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	544600.00	544600.00
210502	Хоол, хүнс	21119300.00	21119300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	362700.00	362700.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	210000.00	210000.00
210604	Урсгал засвар	210000.00	210000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	223200.00	223200.00
210702	Дотоод албан томилолт	223200.00	223200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний</b>	1533700.00	1533700.00

	төлбөр, хураамж		
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1283700.00	1283700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250000.00	250000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>837000.00</b>	<b>837000.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	837000.00	837000.00
<b>13</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>292166100.00</b>	<b>292166100.00</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>280596600.00</b>	<b>280596600.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	280596600.00	280596600.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>11569500.00</b>	<b>11569500.00</b>
132001	Орон нутгийн төсвөөс	11569500.00	11569500.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>25.0</b>	<b>25.0</b>
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	25.00	25.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	22.00	22.00
650010	Гэрээт ажилтан	3.00	3.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>205000</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>205000</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	205000
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	205000
210405	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	205000
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	205000
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	205000
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	205000
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

### **3. Аудитын тайлан**

---

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улаанхус сумын Хөххөтөл хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Уужим алтай Аудит” ХХК-ны аудитор Б.Галымбек гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар хэрэгжүүлсэн.

Улаанхус сумын Хөххөтөл хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 18 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл

Хүүхдийн хөгжлийг дэмжих, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах, амжилттай суралцахад бүх талын хамтын ажиллагаа, оролцоог хангаж хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах, багш, эцэг эх, асран хамгаалагчийн оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлэн, сурлагын хоцрогдлыг арилгах

Улаанхус сумын Хөххөтөл хүүхдийн цэцэрлэгийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тайлант онд Улаанхус сумын Хөххөтөл хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт аудитын албанаас хяналт шалгалт хийгдсэн байна.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаанхус сумын Хөххөтөл хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 316.8 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 4.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 3.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Улаанхус сумын Хөххөтөл хүүхдийн цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 14559.3 мянган төгрөгөөр буюу 1.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	0.00	0.00
Авлага	2349.8	398.2	-1951.6
Урьдчилгаа	0.0	0.0	0.00
Бараа материал	40594.6	40182.3	-412.3
Үндсэн хөрөнгө	720869.6	708674.2	-12195.3
<b>Нийт хөрөнгө</b>	<b>763814.0</b>	<b>749254.7</b>	<b>-14559.2</b>
Өр төлбөр	4116.9	755.6	-3361.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	<b>759697.1</b>	<b>748499.1</b>	<b>-11197.9</b>
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>763814.0</b>	<b>749254.7</b>	<b>-14559.3</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 40.2 сая төгрөг болж 0.4 сая төгрөгөөр буурсан байна. Хүнсний материал данс 13.7 сая төгрөгийн, аж ахуйн материалын данс 13.9 сая төгрөгийн, Бусад хангамжийн материал данс 10.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь бараа материалын нийт үлдэгдлийн 95.0 хувийг эзэлж байна.

Хүнсний материал данснаас урьд жилүүдэд хоолны зардлын төсвөөс авсан гэх нийт 16.7 сая материалыг хүнсний материалд бүртгэж ирснээс цэцэрлэгийн эрхлэгчийн 2021 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн “Хөрөнгийг хооронд зохицуулах тухай” 09 тоот тушаал гаргаж 6.5 сая төгрөгийг үндсэн хөрөнгө дансанд, аж ахуйн материалын дансанд 4.8 шилжүүлэн, 5.4 сая төгрөгийн материалыг данснаас хасжээ.

Өмнөх оны аудитаар хүнсний материалын тооллоготой холбоотой зөрчилтэй асуудал илрээгүй бөгөөд энэхүү зөрчлийг санаатай нуун дарагдуулсан гэж үзэх үндэслэлтэй байна.

Хүнсний материал дансанд оны эхэнд 15.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба 19.8 сая төгрөгийн хүнс худалдан авч 22.0 сая төгрөгийн материалыг зарцуулж жилийн

эцэст 13.7 сая төгрөгийн хүнсний материалын үлдэгдэлтэй гарснаас үзэхэд хүнсний материалыг их хэмжээгээр нөөцөлсөн нь цэцэрлэгийн үйл ажиллагаа зогссонтой холбоотой чанар байдал алдаж муудах эрсдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 708.6 сая төгрөг болж 12.2 сая төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан 1.6 сая, бараа материалаас шилжүүлсэн 6.5 сая төгрөгөөр нэмэгдэж, үндсэн хөрөнгөд 20.3 сая төгрөгийн элэгдэл байгуулснаас шалтгаалжээ. Дусаагүй барилгаас 154.0 сая төгрөгийг барилга байгууламж дансанд шилжүүлэн бүртгэсэн байна.

Өглөг дансны үлдэгдэл 0.7 сая төгрөг болж 3.3 сая төгрөгөөр буурсан байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус цэцэрлэгийн 2021 оны анх батлагдсан төсөв 361.8 сая төгрөг, тодотгосон төсөв 292.1 сая төгрөг байна. Тодотгосон төлөвлөгөө нь анх баталсан төлөвлөгөөнөөс 69.9 сая төгрөгөөр буурсан дүнтэй байна. Үүнд:

Цалин, хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 35.3 сая төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 4.8 сая төгрөгөөр, түлш, халаалтыг 5.7 сая төгрөгөөр, норматив зардал буюу хоолны зардлыг 24.5 сая төгрөгөөр анх баталснаас бууруулж тодотгосон байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд 292.1 сая төгрөгийн төсөв баталснаас 280.6 сая төгрөгийг улсын төсвөөс 11.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 292.1 сая төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагаандаа 292.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нийт төсвийн 76.3 хувийг цалин, 10.3 хувийг НДШ-ийн зардал, 3.9 хувийг тогтмол зардал, 0.9 хувийг хангамж бараа материалын зардал, 7.5 хувийг норматив зардал, 0.05 хувийг урсгал засварын зардал, 0.5 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, 0.2 хувийг бараа үйлчилгээний бусад зардал тус тус эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 0.2 сая төгрөгийн нэмэлт төсөв авч хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгахад зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Улаанхус сумын Хөххөтөл хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Улаанхус сумын Хөххөтөл хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны төсөвт дүн шинжилгээ хийж үзэхэд үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай цалингийн зардалд 223.0 сая төгрөг, НДШ-ийн зардалд 30.1 сая төгрөг, халаалтын зардалд 11.4 сая төгрөг, урсгал засвар, эмийн зардалд 0.7 сая төгрөг, хоолны зардалд 22.0 сая төгрөг нийтдээ 285.6 сая төгрөг зарцуулсан байна.

Нийт санхүүжилтийн орлого болох 292.1 сая төгрөгөөс үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай зардлыг хасахад 6.5 сая төгрөгийн зардлыг тэвчиж болох зардал гэж үзээд тогтоолын дагуу 0.7 сая төгрөгийг хэмнэх тооцоо гарч байгаа Засгийн газрын 2021 оны Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 43 дугаар тогтоолын хэрэгжилт хангагдаагүй байна гэж үзлээ.

### **3.8 Аудитын гол асуудал**

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий дараах ажил гүйлгээ гараагүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Улаанхус сумын Хөххөтөл хүүхдийн цэцэрлэгийн 2021 онд нийт 292.1 сая төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 292.1 сая төгрөгийн 147 мэдээллийг хугацаандаа байршуулж, 2 мэдээллийг буюу 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт байршуулах хугацаа болоогүй байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар цалингийн зардлаас нийгмийн даатгалын шимтгэлд илүү шилжүүлж 1.5 сая төгрөгийн авлага үүсгэсэн зөрчилд албан шаардлага,

цэцэрлэгийн хүүхдийн хоол, хүнсний материалыг бодит хэрэгцээнд үндэслэн худалдан авалт хийх, гарч болох эрсдэлийг урьдчилан тооцож, чанар байдлаа алдаж муудахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах талаар нэг зөвлөмж өгсөн байна. Давтан шалгаж үзэхэд албан шаардлагыг барагдуулсан боловч хоол, хүнсний материалын үлдэгдэл бага хэмжээгээр буурсан байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Хүнсний материалын үлдэгдэл их хэмжээгээр нөөцөлсөн нь анхаарах асуудал байна гэж үзлээ.

## **4. Аудитын илрүүлэлт**

---

Аудитаар нийтдээ 103.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч 103.3 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага өгөгдлөө.

### **4.1 Залруулсан алдаа**

Байхгүй

### **4.2 Төлбөрийн акт**

Байхгүй

### **4.3 Албан шаардлага**

Аудитаар 103.3 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Цэцэрлэг нь хүнсний материалын данснаас урьд жилүүдэд хоолны зардлын төсвөөс авсан гэх нийт 16.7 сая материалыг хүнсний материалд бүртгэж ирснийг Цэцэрлэгийн эрхлэгчийн 2021 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн “Хөрөнгийг хооронд зохицуулах тухай” 09 тоот тушаал гаргаж 6.5 сая төгрөгийг үндсэн хөрөнгө дансанд, аж ахуйн материалын дансанд 4.8 шилжүүлэн, 5.4 сая төгрөгийн материалыг зарцуулснаар данснаас хасахдаа бүрдүүлсэн баримтууд нь тухайн үед бүрдүүлсэн баримт эсэх нь эргэлзээтэй, үнэн зөвийг сумын санхүүгийн албаар хянаж баталгаажуулаагүй байна.

2.Цэцэрлэгийн эрхлэгчийн 2021 оны 12 дугаар сарын 12-ний өдрийн 15 тоот тушаалаар жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийх комиссыг томилж тооллого хийгдсэн боловч зарим хөрөнгийн тооллогын бүртгэлийн дүн нь санхүүгийн тайлангийн үлдэгдлээс зөрүүтэй, зарим хөрөнгийн үлдэгдлийг бүрэн тоолоогүй, нягтлан бодогч нь тооллогын дүнг үндэслэн тооцоо бодож үлдэгдлийг баталгаажуулаагүйгээс нийтдээ 86.5 сая төгрөгийн зөрчилтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл.Нягтлан бодох бүртгэлийн зарчим, 5.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4-д “үнэн зөв байх, 13 дугаар зүйлийн, 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитаар илэрсэн зөрчлийг арилгуулах албан шаардлага өгөгдлөө.

#### 4.4 Зөвлөмж

Байхгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хөххөтөл хүүхдийн цэцэрлэг	1	103.3					1	103.3		